




Төрийн албаны зөвлөлийн дарга




Сонгуулийн ерөнхий хорооны дарга




Хүний эрхийн үндэсний комиссын дарга



Авлигатай тэмцэх газрын дарга



Шүүхийн сахилгын хорооны дарга



Эх сурвалж: (Сангийн яам, 2025)

Дээрх зургаас харвал төсвийн хязгаар болон төсвийн санал нь зарим ерөнхийлөн захирагчдын хувьд ихээхэн зөрүүтэй байна. Үүнд:

- Эрчим хүчний сайд
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
- Сонгуулийн ерөнхий хорооны дарга
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
- Хүний эрхийн үндэсний комиссын дарга
- Зам тээврийн сайд зэрэг төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарч байна.

Эдгээр төсвийн ерөнхийлөн захирагчдын тухайд хязгаараас 212.5-381.0 хувиар давсан төсвийн төсөл боловсруулсан байгаа нь анхаарал татах асуудал юм. Гэтэл Төсвийн тухай хуулийн 31.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлнэ” гэж заасан ч хуулийн энэ заалтыг баримталсан эсэх нь тодорхойгүй. Түүнчлэн урсгал болон хөрөнгийн зардлыг асар их хэмжээгээр нэмэгдүүлсэн саналын цаана үнэхээр бодит хэрэгцээ байна уу, эсвэл шууд захирагч нарын саналыг механикаар нэгтгээд ирүүлсэн эсэхийг тогтоох боломжгүй байна. Гэхдээ төсвийн саналууд явцын дунд өөрчлөгдсөн байх магадлалтай гэдгийг тэмдэглэе. Учир нь, зарим тоо баримт хэлэлцүүлгийн үеэр танилцуулж байснаас өөр байгаа юм. Ямартай ч үүнтэй холбоотой төсвийн төсөл, гүйцэтгэлийн явцад төсвийн хязгаарыг баримтлахгүй байх хууль зөрчсөн үйлдэл давтагдаж байгааг анхаарах шаардлагатай.


Гурав. Олон нийтийн оролцоог хангаж ажилласан, гарсан үр дүнг төсвийн төсөлд тусгасан эсэхэд хийсэн дүн шинжилгээ

УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1.3-т “Төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан, гарсан үр дүнг төсвийн төсөлд тусгасан байдлыг хянах”, 22.2 дахь заалтад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүн шинжилгээ хийж, саналаа бэлтгэн холбогдох талуудад хүргүүлэхээр хуульчилсан.

2023 оны төсвийн эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд төсвийн төсөлд олон нийтийн оролцоог хангах асуудал хөндөгдөж 28¹ дүгээр зүйлд “Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах” гэсэн зохицуулалтыг нэмснээр хэрэгжиж буй шинэ тутам ажил юм.

Төсвийн төслийн боловсруулах явцад олон нийтийн оролцоог хангах асуудлын хүрээнд дүн шинжилгээ хийх зорилгоор журмын шалгууруудыг хураангуйлан дараах зурагт харуулав.


Зураг 2. Төсвийн тухай хуулиар олон нийтийн хэлэлцүүлэг хийх зохицуулалт



Эх сурвалж: (УИХ, 2011)

Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 93 дугаар тогтоолоор "Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам"-ыг баталсан. Энэхүү журамд хэлэлцүүлэг явуулах субъект, хамрах хүрээ, хэлэлцүүлэг явуулах, санал авах хэлбэр, хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгах асуудлыг тусгасан байдаг. Засгийн газрын журам нь зөвхөн төсөв бус, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хувьд хамаарахаар зохицуулсан байна.

Зураг 3. Хэлэлцүүлэг зохион байгуулах журмын зарим заалтууд



Эх сурвалж: (МУЗГ, 2024)

Зардал нэмэгдүүлэх санал өгч байгаа олон нийтийн төлөөлөл зардал бууруулах саналыг мөн өгөх шаардлагатайгаар зохицуулсан нь бодит байдалд хэрэгжих боломж багатай зүйл юм.

ТТБЗ-ийн зүгээс улсын төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хэрхэн хангаж ажилласан, үр дүнг төсвийн төсөлд тусгасан байдлыг дээрх хууль, журмын зохицуулалтын хүрээнд үндсэн дөрвөн шалгуурын хүрээнд дүн шинжилгээг хийлээ.

1. Олон нийтийн хэлэлцүүлэг явуулсан цаг хугацаа, оролцогч талууд, хэлэлцүүлэг явуулах хүрээ

Хуулийн зохицуулалт: Төсвийн тухай хуулийн 28^{1.2}-т “Энэ хуулийн 28^{1.1.1}-д заасан хэлэлцүүлгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 8 дугаар сард, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд дараах журмаар зохион байгуулна”, мөн 28^{1.2.1}, 28^{1.2.2} дахь заалтад оролцогч талууд, хамрах хүрээг заасан байдаг. Засгийн газрын “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-д хэлэлцүүлэг явуулах хэлбэр, салбарыг тодорхой зааж өгсөн байна.

Хэрэгжилт: 2026 оны төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах үүднээс Засгийн газрын зүгээс удирдамж гарган 2025 оны 8 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд зохион байгуулсан. Хэлэлцүүлгийг танхимаар хийхээс гадна E-Mongolia цахим сүлжээ, 11-11 төв, ТЕЗ нарын цахим хуудсыг ашиглан хэрэгжүүлсэн. Танхимын хэлэлцүүлгийг нэг салбарын хувьд 1 цагаас доошгүй хугацаанд үргэлжлэхээр зохион байгуулсан. Сангийн яамны тайланд хэлэлцүүлэгт (Сангийн яам, 2025) танхимаар 1,390 хүн, бусад хэлбэрээр 238,388 иргэн, нийт 239,778 хүн оролцсон нь энэ удаагийн хэлэлцүүлгийн хэрэгжилт цар хүрээг илэрхийлж байна.

Хүснэгт 1. Олон нийтийн хэлэлцүүлгийн хэрэгжилтийн үнэлгээ - 1

д/д	Үзүүлэлт	Шалгуур	Тайлбар
1	Хэлэлцүүлгийн хугацаа	ТТХ, 28 ^{1.2}	Хуульд заасан шалгуурыг хангаж байна. Харин нэг хэлэлцүүлгийн хугацаа 1 цаг орчим байгаа нь хязгаарлагдмал байна.
2	Хэлэлцүүлэгт оролцогчид, хамрах хүрээ	ТТХ, 28 ^{1.2.1}	Хэлэлцүүлэгт оролцогчид төлөөллийн хувьд хуульд заасан шалгуурыг хангаж байсан.
3	Хэлэлцүүлгийн хэлбэр	Журам 1.5	Хэлэлцүүлгийг боломжтой 5 хэлбэр болон бусад гэсэн байдлаар журамласан. Түүний 3 хэлбэрийг ашигласан.

2026 оны төсвийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийн хүрээнд ТТБЗ-ийн дарга, гишүүд оролцож ажилласан байдал, Сангийн яамны тайлан, мэдээлэлд үндэслэн дүгнэхэд хэлэлцүүлгийн хувьд хамрах хүрээ, тоо, хэлэлцүүлгийн цаг хугацааны хувьд анхаарах шаардлагатай нь ажиглагдсан. Нэг өдөр дараалан олон ерөнхийлөн захирагчдын хэлэлцүүлгийг богино хугацаанд нэг танхимд явуулах нь оролцогчдын тоо, хэлэлцүүлгийн чанарт сөргөөр нөлөөлж нэг оролцогчид олон салбарын асуудалд судалгаа, дүн шинжилгээ муутай асуулт, санал хэлж хэлэлцүүлгийн үр дүнг бууруулах хандлага ажиглагдсан.

2. Хэлэлцүүлгээ гарсан саналыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгасан эсэх


Хуулийн зохицуулалт: Төсвийн тухай хуулийн 28^{1.2.3}-т “хэлэлцүүлгээ гарсан эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдол бүхий, зардал бууруулах саналыг нэгтгэн эрэмбэлж, тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахад тусгах” хэмээн хуульчилсан байдаг. Харин Засгийн газрын 2024 оны 93 дугаар тогтоолоор баталсан

журмын 2.9-д хуулийн зохицуулалтаас гадна зардал нэмэгдүүлэх санал нь зардал бууруулах саналтай хамт байх, хөгжлийн төлөвлөгөөнд нийцтэй байх зэрэг шалгуурыг нэмж тусгасан байдаг.

Хэрэгжилт: Олон нийтийн хэлэлцүүлгийн дүнд нийт 8,810 санал гарсан тухай Сангийн яамны тайланд дурджээ. Сангийн яам “Иргэдийн гаргасан 8,810 саналын давхардлыг цэвэрлэж үзэхэд нийт 417 саналд багцлагдаж байна. Эдгээр саналын 151-ийг ТЕЗ нар өөрсдөө эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд эдгээр нь голдуу одоогоор хэрэгжиж байгаа буюу нэгэнт төсөвт тусгагдсан, эсхүл он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээтэй холбоотой байна” гэсэн байна (Сангийн яам, 2025).

Эдгээр саналын 151 нь хязгаарт багтаагүй, төсөвт ямар нэгэн байдлаар тусгагдсан, зураг, төсөл, барилгын магадлалын дүгнэлт хийгдээгүй, төсвийн төсөлд тусгагдах боломжгүй гэх мэт байдлаар төсвийн төсөлд тусгагдаагүй бөгөөд тус бүрд нь үндэслэл тайлбарыг тайланд дурдсан байна. Ингэснээр Сангийн яамны зүгээс үлдсэн 264 саналын 84-ыг төсвийн төсөлд тусгах боломжтой хэмээн үзэж дараах байдлаар тусгасан байна.

Зураг 4. Олон нийтийн саналыг төсвийн төсөлд тусгасан байдал



Эх сурвалж: (Сангийн яам, 2025)

Түүнчлэн дээрх 264 саналаас төсөвт тусгах боломжгүй 180 санал байгаагийн 61 нь “давхардсан” гэдэг шалтгаанаар хасагдсан байна. Төсөвт тусгагдаагүй шалтгаан нь санал болгосон арга хэмжээнүүд нь 2026 оны төсвийн хязгаарт багтаагүй, хөрөнгө оруулалтын шинжтэй, эсхүл бодлогын өөрчлөлт шаардах, шинэчлэл шаардлагатай саналууд зонхилж байна.


Нэгтгэн дүгнэвэл, иргэд, олон нийтийн оролцоо сайн байсан, тэдний гаргасан нийт саналын 1% хүрэхгүй хэсэг нь төсвийн төсөлд тодорхой хэмжээнд тусгагдсан, хамгийн олон санал гарсан 2 дахь салбар болох боловсролын салбарын хувьд тусгагдсан санал нь харьцуулж үзвэл хэт цөөн байгаа буюу нийт саналын 0.17%-ийг эзэлж байгаа нь цаашид хэлэлцүүлгийг илүү үр дүнтэй явуулах, асуулгын загвар, хэлбэрийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Үүнээс гадна энэ удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийн нэг гол үр дүн нь E-Mongolia цахим системийг ашиглан иргэдээс авсан санал асуулга юм. Монгол Улсын насанд хүрсэн нийт иргэдийн 8.2 хувь буюу 188,016 иргэн цахимаар саналаа өгсөн нь томоохон үр дүн байснаас гадна эдгээр иргэдийн төсвийн бодлогын чиглэлд өгсөн саналын үр дүн нь санал асуулгын хувьд онцгой ач холбогдолтой юм. Энэ хүрээнд иргэд дараах чиглэлээр саналаа өгсөн бөгөөд санал асуулгын үр дүнг нь иргэдийн зүгээс төсвийн бодлогын хувьд хүсэж буй хүлээлт гэж үзэхээр байна. Үүнд:

- 2026 онд аль салбарт төсвийг түлхүү чиглүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?
- 2026 онд аль салбарын төсөвт хэмнэлт хийх шаардлагатай гэж та үзэж байна вэ?
- Төсвийн үр ашгийг сайжруулах хүрээнд ямар бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна вэ?
- Ямар төрлийн хөрөнгө оруулалтыг 2026 онд шинээр эхлүүлэхгүй, тэвчиж болно гэж та үзэж байна вэ?
- Татварын бодлогын дэмжлэг үзүүлэх
- Хувийн хэвшилд шилжүүлэх чиг үүрэг

Жишээ нь хамгийн эхний “2026 онд аль салбарт төсвийг түлхүү чиглүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултад иргэдийн зүгээс дараах байдлаар хариулсан байна.

Зураг 5. Төсвийн бодлогын чиглэлийн талаарх иргэдийн санал



Эх сурвалж: (Сангийн яам, 2025)

Дээрх санал нь давхардсан тоогоор өгсөн 490,296 саналын үр дүн бөгөөд иргэдийн хувьд эрүүл мэнд, боловсролын салбарыг чухалчилж байгааг харуулж буй хэрэг юм. Түүнчлэн төрийн захиргаа, төрийн өмчит компаниудын зарцуулалт, сахилга батыг эрс сайжруулах шаардлагатай гэж иргэд үзэж байгаа юм.

д/д	Үзүүлэлт	Шалгуур	Тайлбар
1	Эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдол бүхий, зардал бууруулах	ТГХ 28 ¹ .2.3	Санал асуулгыг хүрээнд ашигласан саналын хуудасны хувьд энэхүү шаардлагыг оруулсан саналын хуудсаар саналыг авсан. Мөн ТЕЗ нар саналыг эрэмбэлсэн тухай тайланд дурдсан.
2	Зардал нэмэгдүүлэх санал нь зардал бууруулах саналтай хамт гарсан байх	Журам 2.9.2	Саналын хуудсанд энэхүү шаардлагыг тусгаагүй.
3	Улсын хөгжлийн төлөвлөгөөнд нийцтэй байх	Журам 9.2.3	Саналын хуудсанд энэхүү шаардлагыг тусгасан.

Энэ удаагийн хэлэлцүүлгийн хүрээнд санал авсан байдал, түүнийг төсөвт тусгасан байдлын хувьд тодорхой үр дүнтэй хэлэлцүүлэг болсон хэдий ч анхаарах шаардлагатай зарим зүйлсийг дурдах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Төсвийн талаарх саналыг яг ямар субъект гаргасан, түүнийг хэрхэн эрэмбэлсэн нь ил тод байх шаардлагатай юм.
- Ер нь төсвийн төсөлд тусгагдаж буй хөрөнгийн зардлын ил тод байдлыг хангаж, санаачлагч, үнэлгээ, эрэмбэлэлтийн үйл явцыг бүрэн ил тод болгох нь төсвийн үр дүнд эерэг нөлөөлнө.
- Мөн олон нийтийн хэлэлцүүлгийн явцад улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан эсэх, зардал нэмэгдүүлэх болон бууруулах саналыг зэрэг гарган санал өгөх боломж энэ удаагийн олон нийтийн хэлэлцүүлэгт хязгаарлагдмал байсан гэдгийг харгалзан дараагийн хэлэлцүүлгүүдэд энэ шалгуурыг тавих эсэхийг тодорхой болгох хэрэгтэй.

3. Төсвийн төсөл боловсруулахад ашигласан тоон мэдээлэл, судалгаа, аргачлалын ил тод байдал, санал өгөх боломж

Хуулийн зохицуулалт: Төсвийн тухай хуульд 28¹.2.4-т “төсвийн төслийг боловсруулахад ашигласан тоон мэдээлэл, судалгаа, аргачлал нь олон нийтэд нээлттэй байж, санал өгөх боломжтой байх” хэмээн зохицуулсан байдаг.

Хэрэгжилт: Олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр ТЕЗ-дын зүгээс товч танилцуулгыг 15 орчим минутын хугацаанд хийж байсан нь энэхүү хуулийн заалтын хэрэгжилтийг хангах нөхцөлийг хараахан бүрдүүлэх боломжгүй байлаа. Тухайн танилцуулга нь төсвийн хязгаар, ТЕЗ-ийн өгсөн санал, түүний тайлбараар хязгаарлагдаж байсан. Энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэх гол үндэслэл нь Төсвийн тухай хуулийн 8.4.3 дахь заалтыг хэрэгжүүлэх явдал юм. Уг заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх” гэж заасан байдаг. Энэ заалтыг хэрэгжүүлж байж, түүний дараа явагдаж байгаа олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогчид мэдээлэлтэй, судалгаатай санал өгөх боломж бүрдэнэ. Мөн дийлэнх төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн хязгаарыг хэтрүүлсэн саналыг олон нийтэд танилцуулж байсан боловч Төсвийн тухай хуулийн 31.2-т заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 31.1.3-т заасан хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлнэ”

гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, олон нийтэд ил тод мэдээлээгүй нь энэхүү хуулийн заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Олон нийтийн хэлэлцүүлгийн хэрэгжилтийн үнэлгээ - 3

д/д	Үзүүлэлт	Шалгуур	Тайлбар
1	Төсвийн төслийг боловсруулахад ашигласан тоон мэдээлэл, судалгаа, аргачлал нь олон нийтэд нээлттэй байж, санал өгөх боломжтой байх	ТТХ 28 ¹ .2.4	ТЕЗ-д төсвийн төслийн саналаа олон нийтэд ил байршуулаагүй, төсвийн хэлэлцүүлгийн үеэр харьцангуй богино хугацаанд хязгаарлагдмал танилцуулга хийж байсан нь хуульд заасан хэмжээнд санал өгөх боломжийг хязгаарласан

Төсвийн төсөлд санал өгч байгаа талууд тухайн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийн боловсруулалтын талаар судалгаа, аргачлалыг мэдсэн байх эрхийг хангасан энэ заалтыг хэрэгжүүлэх нь олон нийтийн хэлэлцүүлэг үр дүнтэй, ач холбогдолтой байхтай ихээхэн уялдаатай юм. Иймд цаашид төсвийн боловсруулалтын үе шатны ил тод байдал, хуулийн хэрэгжилтийг хангах тал дээр анхаарах шаардлагатай.

4. Иргэдээс санал авахад зориулсан хялбаршуулсан танилцуулга бэлтгэсэн байдал

Хуулийн зохицуулалт: Төсвийн тухай хуулийн 28¹.2.5-д “олон нийтийн хэлэлцүүлэгт зориулж санал авах асуудлаар хялбаршуулсан танилцуулгыг боловсруулах” хэмээн заасан байдаг.

Хэрэгжилт: Олон нийтийн хэлэлцүүлгийн явцад ТЕЗ-ийн зүгээс танилцуулга хийж, санал авах хуудсыг тараах байдлаар энэ зохицуулалтыг хэрэгжүүлсэн. Уг саналын хуудсанд санал өгч буй оролцогчдын мэдээлэл “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-ын 2.9-д тусгагдсан шалгууруудыг санал авах шалгуур болгосон байсан. Энэ нь хялбаршуулсан танилцуулга боловсруулж, оролцогчдод танилцуулсан байдлын шалгуурыг бүрэн хангахгүй юм.

Хүснэгт 4. Олон нийтийн хэлэлцүүлгийн хэрэгжилтийн үнэлгээ - 4

д/д	Үзүүлэлт	Шалгуур	Тайлбар
1	Олон нийтийн хэлэлцүүлэгт зориулж санал авах асуудлаар хялбаршуулсан танилцуулгыг боловсруулах	ТТХ 28 ¹ .2.5	Төсвийн олон нийтийн хэлэлцүүлэгт оролцсон талуудад зөвхөн төсвийн төсөлд өгөх саналын хуудас тарааж өгсөн нь энэ заалтын хэрэгжилтийг бүрэн хангах боломжийг бүрдүүдээгүй.

Олон нийтийн хэлэлцүүлгийг хэрэгжүүлэхэд гол нөлөөлөх асуудал нь иргэд, оролцогчдын мэдээллийн боломж юм. Иргэн бүр төсвийн талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй байх боломж хязгаарлагдмал тул нэгэнт хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа бол оролцогчдыг мэдээлдээр хангах нь чухал юм.

Дөрөв. Дүгнэлт, санал

2026 оны төсвийн төсөлд олон нийтийн оролцоог хангах хуулийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 8 дугаар сарын 4-15-ны өдрүүдэд зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлгийг тодорхой үр дүн бүхий хэлэлцүүлэг болж чадсан гэж ТТБЗ-ийн зүгээс дүгнэж байна.

Үүний шалтгаан нь энэ удаагийн хэлэлцүүлэг нь анх удаа салбар бүрээр хийсэн, иргэдийн саналыг өргөн хүрээнд авч, түүний үр дүнг тодорхой хэмжээнд төсөвт тусгасан, Сангийн яамны зүгээс уг хэлэлцүүлгийн талаар дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж, түүн дотроо ирсэн саналыг тусгагдсан, эс тусгагдсанаар нь ангилж, шалтгааныг дурдсан нь төсөв боловсруулах үйл явцын хувьд гарч буй нэг том дэвшил гэж үзэж байгаа явдал юм. Гэхдээ хэлэлцүүлгийн үр дүнг нэмэгдүүлэхийн тулд хуулийн хэрэгжилт, хэлэлцүүлгийн бодлого, зохион байгуулалтыг сайжруулах шаардлага байгааг мөн дурдах хэрэгтэй. Хэлэлцүүлгийн хувьд ТЕЗ нарын мэдээллийн ил тод байдал хангагдаагүй, оролцогчдыг мэдээлэл, танилцуулгаар хангах байдал сул, хэлэлцүүлгийн цаг ихээхэн шахуу гэх мэт сул талууд байсан гэдгийг анхаарч дараагийн хэлэлцүүлгүүдэд анхаарах шаардлагатай.

Иймд энэ удаагийн хэлэлцүүлэгт ТТБЗ-ийн зүгээс хуульд заасан үүргийн дагуу оролцсон оролцоо, Сангийн яамны тайлан мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээнд суурилан төсвийн хязгаарыг баримтлах байдал, олон нийтийн хэлэлцүүлгийг үр дүнтэй болгох үүднээс дараах саналуудыг гаргаж байна. Үүнд:

- **Төсвийн хязгаарыг чанд баримталж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь чухал.** Төсвийн тухай хуулийн 10.1.2 дахь заалтын дагуу Засгийн газар “Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр жилийн төсвийн хязгаар батлан”, жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт дараа оны төсвийн удирдамжийн хамт хүргүүлдэг. Сангийн яамнаас ТТБЗ-д албан ёсоор ирүүлсэн мэдээллээс үзвэл улсын төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн хязгаараас нийт зарлагыг 49.6%, урсгал зардлыг 25.6%, хөрөнгийн зардлыг 145.2%-аар давуулан, харин эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 2.3%-аар багасгасан дүнгээр Сангийн яаманд төсвийн төсөл хүргүүлсэн байна. Түүний дотор төсвийн хөрөнгө оруулалтын нийт зардлыг төсвийн хязгаараас 2.5 дахин нэмэгдүүлсэн саналыг ТЕЗ нар гаргасан байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөж, бодит үр дүнтэй, үр ашигтайгаар хэрэгжүүлэх, төсвийн хязгаарт багтаан урсгал болон хөрөнгийн зардлаа тооцож боловсруулах шаардлагатайг илтгэж байна.
- **Төсвийн боловсруулалтын шатанд хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.** Төсвийн ерөнхийлөн захирагч нарт Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасан “төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх” зохицуулалтыг хэрэгжүүлж хэвшүүлэх хэрэгтэй. Ингэснээр төсвийн төсвийн боловсруулалтын шатны ил тод байдал хангагдахаас гадна төсвийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогчид төдийгүй бусад талууд мэдээллээр хангагдах боломж нэмэгдэнэ. Улс орны эдийн засаг, төсвийн өнөөгийн нөхцөл

байдлаас харвал ТЕЗ нарын санал болгосон, төсвийн хязгаараас давсан урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэх боломж хомс байгаа тул ТЕЗ бүр төсвийн хязгаартаа багтаан (байгаа боломжит нөөцийнхөө хүрээнд) **төсвийн зарлагаа салбарын хүрээндээ эрэмбэлэх, хөтөлбөр хооронд шилжүүлж удирдах** нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байна.

- **Төсвийн төлөвлөлтийг бодлогын чиг баримжаатай, хөгжлийн бодлого төлөвлөлтөд чиглүүлэх нь зүйтэй.** Хэлэлцүүлэгт оролцох явцад нийтлэг ажиглагдаж буй зүйл бол төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрийн харьяа байгууллагууд, төсвийн шууд захирагч нарын төсвийн саналыг зөвхөн нэгтгэх, дамжуулах үүргийг түлхүү гүйцэтгэж байна. Зүй нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус салбарын хөгжлийн зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг ямар хүч нөөцөөр, ямар арга замаар хэрэгжүүлэх нь оновчтой вэ? гэдгийг судалж, дүн шинжилгээ хийж, хамгийн оновчтой, өртөг зардал, хүн хүч бага шаардагдах арга замыг олох ёстой. Иймээс цаашид Төсвийн тухай хуульд төсвийн төслийг боловсруулах явцад Төсвийн ерөнхийлөн захирагчийн гүйцэтгэх үүргийг илүү тодорхой болгон тусгах шаардлагатай гэж үзэж байна
- **Хэлэлцүүлгийн чанарыг сайжруулах тал дээр анхаарах шаардлагатай.** Төсвийн төслийн хэлэлцүүлэгт иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, танилцуулга мэдээлээр хангах, санал өгөх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчид нь Төсвийн тухай хуулийн 28¹.2.4-т заасан “төсвийн төслийг боловсруулахад ашигласан тоон мэдээлэл, судалгаа, аргачлал нь олон нийтэд нээлттэй байж, санал өгөх боломжтой байх” болон нийтийн хэлэлцүүлэгт зориулж санал авах асуудлаар хялбаршуулсан танилцуулгыг боловсруулж, олон нийтэд урьдчилан мэдээлж, Төсвийн тухай хуулийн 28¹.2.5-д заасан заалтыг хангах үүргийг хэрхэн хэрэгжүүлсэн нь тодорхойгүй байгааг анхаарах нь чухал.
- **Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд өгсөн саналын ил тод байдлыг хангах нь олон нийтийн оролцооны үр дүнг нэмэгдүүлнэ.** Журмын дагуу “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр” авч байгаа саналуудыг нээлтэй, ил тод болгож, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын санаачлагч, үнэлгээ, төсөвт тусгагдсан байдлыг ил тод болгох шаардлагатай. Ингэснээр төсвийн төсөлд ямар зорилгоор, хэн санаачилж хөрөнгө оруулалтыг тусгаж байгаа нь нийтэд ил тод болж, олон нийт дүн шинжилгээ хийх боломж бүрдэнэ.
- **Олон нийтийн оролцоог бодлогын түвшинд чухалчлах шаардлагатай байна.** Төсвийн олон нийтийн хэлэлцүүлэгт иргэдийн оролцоог тодорхой санал гаргах үүднээс гэхээс илүүтэй бодлогын оролцоог нэмэгдүүлэх шаардлага өндөр байж болзошгүй харагдаж байна. E-Mongolia системээр авсан санал асуулгаар иргэд боловсрол, эрүүл мэндийн салбарыг чухалчилж, нийгмийн халамжийг бууруулах, төрийн өмчит компаниудын сахилга хариуцлагыг сайжруулах, татварын дарамтыг багасгах зэрэг саналыг өгсөн нь үүний нэг илрэл юм.

- Үр дүнд чиглэсэн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн тогтолцоог үр дүнтэйгээр бүрдүүлж, хэрэгжүүлэх нь чухал байна. ТЭЗ нь Засгийн газраас тогтоосон төсвийн хязгаарын хүрээнд үндсэн чиг үүргийнхээ дагуу жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүрэхээр зорьж буй үр дүнгийн болон хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг ханган ажиллах болдог. Гэтэл ТЭЗ нарын 2026 оны төсвийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр төсвийн хязгаарт багтаан, эсвэл төсвийн төслийн саналд тусгагдсан хязгаараас давсан зарлагыг гаргаснаар чухам ямар үр дүнд хүрч, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй ажиллах талаар мэдээлэл, танилцуулгыг үндсэндээ хийгээгүй тул УИХ, Засгийн газрын зүгээс үүнд онцгой анхаарч ажиллахыг санал болгож байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ